



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/001/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

АДАС.02.24 № А03
танай АДАС.01.24-ны № 6 -Т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
11 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ОЮУНЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант жилд нийгмийн даатгалын систем шинэчлэгдэж, төрийн алба хаагчдын цалингийн нэгдсэн системд ажил мэргэжлийн код болон даатгуулагчийн кодыг зөрүүтэй оруулснаас ажилтнаас илүү дутуу шимтгэл суутгах, байгууллагаас төлөх шимтгэлийн хэмжээг илүү дутуу тооцоолсноос шалтгаалан жилийн эцэст авлага, өр төлбөр үүсэж тайланд залруулгууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022055

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилго, 9 зорилт, 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Боловсролын газраас 89.8 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	139,026,857.49	225,426,246.82
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	88,367,860.98	172,565,487.73
33	АВЛАГА	88,367,860.98	172,565,487.73
35	БАРАА МАТЕРИАЛ	50,658,996.51	52,860,759.09
351	Түүхий эд материал	180,600.00	
35130	Эм боох материал	180,600.00	
354	Хангамжийн материал	50,478,396.51	52,860,759.09
35410	Бичиг хэргийн материал	673,154.00	234,566.00
35420	Аж ахуйн материал	61,600.00	606,000.00
35430	Бусад хангамжийн материал	49,743,642.51	52,019,593.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,445,296,932.13	1,421,058,140.38
392	Биет хөрөнгө	1,370,296,932.13	1,346,058,140.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,556,067,137.00	1,556,067,137.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(207,782,443.36)	(242,549,289.64)
39203	Бусад үндсэн хөрөнгө	30,700,582.00	30,700,582.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,833,374.00)	(19,653,849.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,930,491.50	50,963,497.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,360,677.86)	(33,336,188.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,041,209.70	28,082,752.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,610,401.19)	(24,216,500.54)
393	Биет бус хөрөнгө	75,000,000.00	75,000,000.00
39301	Програм хангамж	1,793,500.00	1,793,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,793,500.00)	(1,793,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	75,000,000.00	75,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,584,232,789.62	1,646,484,387.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	122,445,232.20	122,445,232.20
51101	Өмч: - төрийн	122,445,232.20	122,445,232.20
512	Хуримтлагдсан үр дүн	1,360,500,958.42	1,422,661,556.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,360,500,958.42	1,360,500,958.42
51220	Тайлант үеийн үр дүн		62,160,597.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зерүү	101,377,599.00	101,377,599.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,584,232,789.62	1,646,484,387.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	737,662,664.00	840,417,874.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	149,516,164.00	27,018,174.55
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	147,554,389.00	15,888,474.55
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1,961,775.00	11,129,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	588,146,500.00	813,399,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	570,480,500.00	788,221,200.00
1320	Орон нутгийн төсвөөс сөнхүүжих	17,666,000.00	25,178,500.00

Дорнод аймгийн Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	540,480,500.00	788,221,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>564,598,188.87</u>	<u>778,257,276.97</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>564,598,188.87</u>	<u>778,257,276.97</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>556,935,280.97</u>	<u>776,322,963.68</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	<u>369,086,940.02</u>	<u>532,730,783.71</u>
210101	Үндсэн цалин	270,671,814.92	367,748,293.71
210102	Нэмэгдэл	83,302,024.74	128,204,120.00
210104	Урамшуулал	15,113,100.36	36,778,370.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	<u>46,853,447.40</u>	<u>65,595,702.63</u>
210201	Тэтгэврийн даатгал	32,117,345.44	45,398,372.02
210202	Тэтгэмжийн даатгал	3,749,336.33	5,304,249.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,975,116.00	2,762,145.21
210204	Ажилгүйдлийн даатгал	725,126.80	2,302,918.64
210205	Эрүүл мэндийн даатгал	7,286,522.83	9,828,017.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	<u>17,145,542.10</u>	<u>21,644,186.71</u>
210301	Гэрэл, цахилгаан	3,166,001.21	3,355,082.63
210302	Түлш, халаалт	7,216,871.89	8,962,890.08
210303	Цэвэр, бохир ус	6,762,669.00	9,326,214.00
2104	Хангамж, бараа материалын зардал	<u>541,880.00</u>	<u>11,359,337.42</u>
210401	Бичиг хэрэг	165,130.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	376,750.00	
210408	Бараа материал акталсны зардал		11,359,337.42
2105	Нормативт зардал	<u>70,047,375.00</u>	<u>79,950,450.00</u>
210503	Норм хувцас зөөлөн эдлэл	853,800.00	
210502	Хоол, хүнс	69,193,575.00	79,950,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	<u>1,339,250.00</u>	<u>1,215,700.00</u>
210604	Урсгал засвар	1,339,250.00	1,215,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	<u>885,000.00</u>	<u>810,000.00</u>
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	885,000.00	810,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	<u>51,035,846.45</u>	<u>63,016,803.21</u>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,582,201.35	15,927,786.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,224,593.26	5,710,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,229,051.84	41,378,966.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>7,662,907.90</u>	<u>1,934,313.29</u>
2132	Бусад урсгал шилжүүлэг	<u>7,641,700.00</u>	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,641,700.00	
2134	Улсын төсвөөс олгосон санхүүжилт. шилжүүлэг	<u>21,207.90</u>	<u>1,934,313.29</u>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,207.90	1,934,313.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>173,064,475.13</u>	<u>62,160,597.58</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>173,064,475.13</u>	<u>62,160,597.58</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>588,146,500.00</u>	<u>813,399,700.00</u>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	570,480,500.00	788,221,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	17,666,000.00	25,178,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>534,344,253.77</u>	<u>729,202,073.25</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>534,344,253.77</u>	<u>729,202,073.25</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>526,681,345.87</u>	<u>727,267,759.96</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	<u>369,086,940.02</u>	<u>532,730,783.71</u>
210101	Үндсэн цалин	270,671,814.92	367,748,293.71
210102	Нэмэгдэл	83,302,024.74	128,204,120.00
210103	Урамшуулал	15,113,100.36	36,778,370.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	<u>46,853,447.40</u>	<u>65,595,702.63</u>
210201	Тэтгэврийн даатгал	32,117,345.44	45,398,372.02
210202	Тэтгэмжийн даатгал	3,749,336.33	5,304,249.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,975,116.00	2,762,145.21
210204	Ажилгүйдлийн даатгал	725,126.80	2,302,918.64
210205	Эрүүл мэндийн даатгал	7,286,522.83	9,828,017.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	<u>17,145,542.10</u>	<u>21,644,186.71</u>
210301	Гэрэл, цахилгаан	3,166,001.21	3,355,082.63
210302	Түлш, халаалт	7,216,871.89	8,962,890.08
210303	Цэвэр, бохир ус	6,762,669.00	9,326,214.00
2105	Нормативт зардал	<u>69,193,575.00</u>	<u>79,950,450.00</u>
210502	Хоол хүнс	69,193,575.00	79,950,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	<u>499,250.00</u>	<u>1,600,000.00</u>
210604	Урсгал засвар	499,250.00	1,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	<u>885,000.00</u>	<u>810,000.00</u>
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	885,000.00	810,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	<u>23,017,591.35</u>	<u>24,936,636.91</u>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,490,591.35	16,856,936.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,527,000.00	8,079,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>7,662,907.90</u>	<u>1,934,313.29</u>
2132	Бусад урсгал шилжүүлэг	<u>7,641,700.00</u>	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,641,700.00	
2134	Улсын төсвөөс олгосон санхүүжилт. шилжүүлэг	<u>21,207.90</u>	<u>1,934,313.29</u>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,207.90	1,934,313.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>53,802,246.23</u>	<u>84,197,626.75</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	<u>53,802,246.23</u>	<u>84,197,626.75</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>34,565,614.75</u>	<u>88,367,860.98</u>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>88,367,860.98</u>	<u>172,565,487.73</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<u>122,445,232.20</u>	<u>101,377,599.00</u>	<u>1,360,500,958.42</u>	<u>1,584,323,789.62</u>
Тайлант үеийн үр дүн			62,160,597.58	62,160,597.58
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<u>122,445,232.20</u>	<u>101,377,599.00</u>	<u>1,422,661,556.00</u>	<u>1,646,484,387.20</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		88,367,860.98	(88,367,860.98)
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	876,588,900.00	704,023,573.25	172,565,326.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	876,588,900.00	704,023,573.25	172,565,326.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	876,588,900.00	704,023,573.25	172,565,326.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	675,793,000.00	532,730,783.71	143,062,216.29
210101	Үндсэн цалин	489,620,700.00	367,748,293.71	121,872,406.29
210102	Нэмэгдэл	172,242,600.00	128,204,120.00	44,038,480.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт			
210104	Урамшуулал	13,929,700.00	36,778,370.00	(22,848,670.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,090,000.00	65,595,702.63	12,494,297.37
210201	Тэтгэврийн даатгал	53,102,700.00	45,398,372.02	7,704,327.98
210202	Тэтгэмжийн даатгал	6,245,600.00	5,304,249.53	941,350.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,123,600.00	2,762,145.21	361,454.79
210204	Ажилгүйдлийн даатгал	3,123,600.00	2,302,918.64	820,681.36
210205	Эрүүл мэндийн даатгал	12,494,500.00	9,828,017.23	2,666,482.77
2105	Нормативт зардал	91,906,500.00	79,950,450.00	11,956,050.00
210502	Хоол хүнс	91,906,500.00	79,950,450.00	11,956,050.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,930,100.00	810,000.00	2,120,100.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	2,930,100.00	810,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,869,300.00	24,936,636.91	2,932,663.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,789,600.00	16,856,936.91	2,932,663.09
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,079,700.00	8,079,700.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	876,588,900.00	788,221,200.00	88,367,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	788,221,200.00	788,221,200.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	788,221,200.00	788,221,200.00	-

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	88,367,860.98	(858,367,860.98)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	172,565,487.73	(172,565,487.73)
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26	26	
620001	Удирдах ажилтан	1	1	
620002	Гүйцэтгэх ажилтан	17.5	17.5	
620003	Үйлчлэх ажилтан	7.5	7.5	

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,178,500.00	23,244,186.71	1,934,313.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,178,500.00	23,244,186.71	1,934,313.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,178,500.00	23,244,186.71	1,934,313.29
2103	БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	23,578,500.00	21,644,186.71	1,934,313.29
210301	Гэрэл, цахилгаан	3,235,000.00	3,355,082.63	(120,082.63)
21302	Түлш халаалт	7,439,900.00	8,962,890.08	(1,522,990.08)
21303	Цэвэр, бохир ус	12,903,600.00	9,326,214.00	3,577,386.00
	Эд хогшил худалдан авах	1,600,000.00	1,600,000.00	-
210604	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00	-
	Урсгал шилжүүлэг	-	1,934,313.29	-
	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,934,313.29	-

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8.8 сая төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалаар бүртгэсэн 6.9 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд шилжүүлж бүртгүүлж залруулав. Энэ нь УСНББОУС 01, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Шууд зардалд бүртгэсэн 1.9 сая төгрөгийн хөрөнгийн дагалдах хэрэгслийг хөрөнгөөр бүртгэж залруулав. Энэ нь УСНББОУС 01, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 74.0 сая төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс 0.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 73.9 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэв.

2.1 Төлбөрийн акт

1. Томилолтын хуудсыг иж бүрэн бөглөөгүй 0.1 сая төгрөгөөр зардлыг илүү тооцож олгосон нь Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага шалгуур журмын 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Албан шаардлага

1. Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, нярав нар тус бүр 160.0 хувиар тооцон 3.8 сая төгрөгийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчин Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор тогтоосон урамшууллын хэмжээг хэтрүүлэн олгосон, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Тендерээр худалдан авалтын 70.1 сая төгрөгийн гэрээг буруу дүгнэж акт үйлдсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Захиалагч энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалаар бүртгэсэн байсан хөрөнгийг үндсэн хөрөнгөд шилжүүлж бүртгүүлж залруулав.	1	6,904.0					1	6,904.0				
Шууд зардалд бүртгэсэн хөрөнгийн дагалдах хэрэгслийг хөрөнгөөр бүртгэж залруулав.	1	1,900.0					1	1,900.0				
Дүн	2	8,804.0					2	8,804.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Томилолтын хуудсыг иж бүрэн бөглөөгүй илүү тооцож олгосон	1	90.0	1	90.0								
Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, нярав нарт олгосон	1	3,769.5			1	3,769.5						

Дорнод аймгийн Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тендерээр худалдан авалтын гэрээг буруу дүгнэж акт үйлдсэн	1	70,125.0			1	70,125.0						
Дүн	3	73,984.5	1	90.0	2	73,894.5						



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 37 /199023199
ДТТ-2025 / 001 / НА-ЦТН-ТУС

Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус цэцэрлэг нь албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, зардлын хэмжээг 90,000.00 төгрөгөөр хэтрүүлэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам” -ын 2.5.-д “Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, хоол, унааны зардлын төсвийг байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална”, 2.6-д “Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчид томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр, батлагдсан зардлын төсвийг үндэслэн томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг урьдчилан олгоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ыг мөрдөөгүй болон илүү зарцуулсан 90,000.00 /ерөн мянган/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Д.Оюунчимэг, нягтлан бодогч Г.Ганцолмон нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

“ХААН КОНСАЛТИНГ АУДИТ” ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ

217744066
ХТҮ/07 9000391



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 107 /19925199

Чойбалсан хот

АТА - 2025 /001 /НА- ОА-ТШС

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах 70,125,000.00 төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэхдээ гэрээний үнэ болон нийлүүлэх бараа бүтээгдхүүний мэдээлэл, холбогдох нотлох баримтыг бүрдүүлээгүй, хуваарийн дагуу бараа бүтээгдхүүнийг нийлүүлээгүй, тоо хэмжээнээс илүү худалдан авалт хийсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх" зарчим, 39 дүгээр зүйлийн 39.3-т "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана", 39.3.1-д "гэрээний үнэ", 39.3.2-т "гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл", 39.3.6-д "бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх хуваарь", 48 дугаар зүйлийн 48.2.7-т "Худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх", 48.2.9-т "Энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах", 47.3-т "Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 дэх "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол", 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу хийж, худалдан авах гэрээнд тусгах нөхцлүүдийг бүрэн тусгасан байх, хуваарийн дагуу худалдан авалтыг

2125040303

- зохион байгуулж хянах, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Хууль эрх зүйн шийдвэрийг баримтлан ажиллахыг Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Д.Оюунчимэг, нягтлан бодогч Г.Ганцолмон нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 108/19125199

Чойбалсан хот

СТА-АХС/001/НА-СТА-ТУС

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогчид 1-1.5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 3,769,500.00 төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Д.Оюунчимэг, нягтлан бодогч Г.Ганцолмон нарт даалгав.

2125040304

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ

